



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/016-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Аудитор: Утас: 70363036	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ж.Цогт Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.	12-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15-19
4. Аудитын тайлан.....	19-23
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20-22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22-23
5. Аудитын илрүүлэлт	23-26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	27-28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.ГАНБОЛД ТАНАА

2025.03.25 № СЭА-2025/016-НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

СЭА-2025/016-НА-СТА-ТТЗ

3
432502399

- Сумын ЭМТ-ийн дарга албан тушаалтай Б.Алтан-Өлзийгийн ажилгүй байсан хугацааны **4,000.0** мянган төгрөгийн цалинг сумын ЗДТГ-ын төсвөөс барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй,
- Сумын ИТХ-ын тогтоолоор ОНХС-аас эх үүсвэрээс “Баяр наадмын зардал”-д 106,975.8 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоосон боловч **1,524.2** мянган төгрөгийг илүү зарцуулсан,
- ЗДТГ нь бүрдэл дутуу анхан шатны баримтаар **10,279.7** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- ИТХ, Дулаанхан тосгоны Захирагчийн алба нь батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн, зориулалт бусаар нийт **7,763.0** мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **3,879.6** мянган төгрөгийг зарцуулсан,
- Шилэн дансанд мэдээлбэл зохих 12 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг огт мэдээлээгүй,
- ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан **28,895.9** мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 126 дугаар тогтоолоор татварын болон татварын бус нийт 970,138.5 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,370,624.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 141.3 хувиар биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд үндэсний их баяр наадам, сум байгуулагдсаны тэгш ойг зохион байгуулах үйл ажиллагаанд ОНХС-аас **108,500.0** мянган төгрөг буюу тус сангийн нийт төсвийн **25.4** хувийг зарцуулсан байгаа нь ОНХС-ийн “орон нутгийн хөгжлийг дэмжих” үндсэн зорилгыг алдагдуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Шаамар сумын Засаг дарга нь тайлант онд 20 зорилт, 204 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 87.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,028,837.8	1,507,057.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	318,496.2	781,905.6
33	АВЛАГА	200,343.8	189,573.2
35	БАРАА МАТЕРИАЛ	509,997.8	535,578.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,475,855.5	7,050,402.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,475,855.5	7,050,402.3
39200	Биет хөрөнгө	6,342,410.2	6,844,983.0
39300	Биет бус хөрөнгө	133,445.3	205,419.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,504,693.3	8,557,459.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	154.9	1,121.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	154.9	1,121.3
41300	Өглөг	154.9	1,121.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,504,538.4	8,556,338.3
51	Засгийн газрын хувь оролцоо	7,504,538.4	8,556,338.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	693,139.5	693,139.5
51200	Хуримтлагдсан үр дүн	5,241,541.2	6,293,341.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,569,857.8	1,569,857.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,504,693.3	8,557,459.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,246,578.0	4,307,817.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	619,167.2	1,036,798.9
110	Орлогын албан татвар	407,870.0	882,924.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	470,788.1	945,809.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(62,918.1)	(62,885.0)
113	Хөрөнгийн албан татвар	47,884.5	44,527.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	163,412.7	109,346.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,839,047.8	1,543,182.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,839,047.8	1,543,182.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,788,363.0	1,727,836.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,311,450.7	3,173,517.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,311,450.7	3,173,517.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,309,050.7	3,115,563.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,277.5	1,090,579.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,988.1	139,217.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	157,910.2	727,826.9
2104	Хангамж, бараа материалын зардал	204,437.6	86,462.9
2105	Нормативт зардал	2,547.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,969.6	91,825.2
2107	Томилолт, зочны зардал	4,856.5	3,125.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	665,720.7	220,916.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	506,343.5	755,609.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400.0	57,954.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,935,127.3	1,134,299.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	289,135.2	82,500.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,645,992.1	1,051,799.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,858,546.3	5,858,546.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,858,546.3	5,858,546.3
9	Тайлант үеийн үр дүн	1,645,992.1	1,645,992.1
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,504,538.4	7,504,538.4
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,504,538.4	7,504,538.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,504,538.4	7,504,538.4
19	Тайлант үеийн үр дүн	1,051,799.9	1,051,799.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,556,338.3	8,556,338.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,690,951.7	4,408,531.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	619,167.2	1,036,798.9
110	Орлогын албан татвар	407,870.0	882,924.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	470,788.1	945,809.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(62,918.1)	(62,885.0)
113	Хөрөнгийн албан татвар	47,884.5	44,527.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	163,412.7	109,346.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	82,396.2	38,596.4
1181	Газрын төлбөр	77,754.8	67,061.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,261.7	3,688.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	304,288.0	424,196.3
120	Нийтлэг татварын бус орлого	304,288.0	424,196.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,767,496.5	2,947,536.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,784,863.2	3,612,607.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,784,863.2	3,612,607.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,782,463.2	2,320,966.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	662,169.2	1,090,399.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,894.1	139,217.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,216.0	727,223.8
2104	Хангамж, бараа материалын зардал	83,600.2	82,444.4
2105	Нормативт зардал	2,547.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,133.4	88,320.3
2107	Томилолт, зочны зардал	4,856.5	3,125.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	678,735.0	110,861.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,311.8	79,373.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400.0	1,291,641.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	906,088.6	795,924.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	999,427.9	246,751.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	999,427.9	246,751.0
2200	Дотоод эх үүсвэрээр	999,427.9	246,751.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(999,427.9)	(246,751.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(85,764.1)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	85,764.1

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(93,339.4)	463,409.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	411,835.6	318,496.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	318,496.2	781,905.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,007,010.2	2,692,376.8	314,633.4	89.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,449,444.5	2,377,148.7	72,295.8	97.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,376,529.9	2,305,207.7	71,322.2	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,111,293.0	1,090,399.5	20,893.5	98.1
210101	Үндсэн цалин	624,831.6	581,074.7	43,756.9	93.0
210102	Нэмэгдэл	344,231.2	426,238.9	(82,007.7)	123.8
210104	Урамшуулал	32,799.8	25,243.0	7,556.8	77.0
210105	Гэрээт ажлын хөлс	109,430.4	57,842.9	51,587.5	52.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,021.8	139,217.9	4,803.9	96.7
210201	Тэтгэврийн даатгал	97,346.1	93,768.5	3,577.6	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	10,879.1	10,740.2	138.9	98.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,621.8	8,254.1	367.7	95.7
210204	Ажилгүйдлийн даатгал	5,417.0	5,336.5	80.5	98.5
210205	Эрүүл мэндийн даатгал	21,757.8	21,118.7	639.1	97.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	765,292.2	724,781.0	40,511.2	94.7
210301	Гэрэл, цахилгаан	111,610.3	87,904.4	23,705.9	78.8
210302	Түлш, халаалт	636,371.9	623,025.6	13,346.3	97.9
210303	Цэвэр, бохир ус	17,310.0	13,850.9	3,459.1	80.0
2104	Хангамж, бараа материалын зардал	82,014.4	82,014.4	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	16,606.3	15,953.2	653.1	96.1
210402	Тээвэр, шатахуун	39,202.0	39,195.6	6.4	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,214.5	5,496.3	(281.8)	105.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,800.0	6,800.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,191.6	14,569.3	(377.7)	102.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,612.6	91,274.4	1,338.2	98.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,924.9	6,258.7	(333.8)	105.6
210602	Тавилга	2,139.6	2,000.1	139.5	93.5
210604	Урсгал засвар	84,548.1	83,015.6	1,532.5	98.2
2107	Томилолт, зочны зардал	3,500.0	3,125.3	374.7	89.3
210702	Дотоод албан томилолт	3,500.0	3,125.3	374.7	89.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,307.9	118,917.8	3,390.1	97.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,941.7	112,053.1	1,888.6	98.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,063.3	1,500.0	563.3	72.7
210803	Даатгалын үйлчилгээ	1,187.0	440.8	746.2	37.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	978.9	925.3	53.6	94.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90.0	-	90.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	63.2	17.6	45.6	27.8
210807	Газрын төлбөр	3,681.6	3,678.8	2.8	99.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	302.2	302.2	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,488.0	55,477.4	10.6	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,394.2	54,387.4	6.8	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,093.8	1,090.0	3.8	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,914.6	71,941.1	973.5	98.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,914.6	71,941.1	973.5	98.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,460.6	30,487.1	973.5	96.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,454.0	40,454.0	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.0	1,000.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	436,394.0	229,463.9	206,930.1	52.6
220001	Барилга байгууламж	191,000.0	10,507.8	180,492.2	5.5
223001	Бусад хөрөнгө	245,394.0	218,956.1	26,437.9	89.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	121,171.7	85,764.1	35,407.6	70.8
230001	Эргэж төлөгдөх зээл	121,171.7	85,764.1	35,407.6	70.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,007,010.2	2,822,545.8	184,464.4	93.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,810,394.3	2,732,175.2	78,219.1	97.2
320001	Орон нутгийн төсвөөс	2,483,944.9	2,421,590.5	62,354.4	97.5
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	326,449.4	310,584.7	15,864.7	95.1

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	196,615.9	90,370.6	106,245.3	46.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,140.0	90,370.6	(8,230.6)	110.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	114,475.9	-	114,475.9	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	154,964.0	(154,964.0)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	285,133.1	(285,133.1)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	87.0	87.0	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.0	3.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	3.0	3.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.0	42.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	8.0	8.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.0	14.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12.0	12.0	-	100.0
620004	Гэрээт ажилтан	8.0	8.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42.0	0.0	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.0	16.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	12.0	12.0	-	100.0
650010	Гэрээт ажилтан	8.0	8.0	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.0	6.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,445.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,445.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,949.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,442.8
210301	Гэрэл, цахилгаан	2,442.8
2104	Хангамж, бараа материалын зардал	430.0
210402	Тээвэр, шатахуун	130.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,333.0
210604	Урсгал засвар	1,333.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,944.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,944.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,495.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,495.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	23,495.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,445.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,445.6
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	187.7
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,834.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,423.9

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шаамар сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлалд түшиглэсэн бизнес нь тогтвортой хөгжсөн, иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин бүрдсэн хөгжлийн түвшингээрээ аймагтаа тэргүүлэх сумдын нэг болох” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2024 онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус сумын ХХС-ийн 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийж 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлсэн бол ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шаамар сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,052,766.4 мянган төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	318,496.2	781,905.6	463,409.4
Авлага	200,343.8	189,573.2	(10,770.6)
Бараа материал	509,997.8	535,578.6	25,580.8
Үндсэн хөрөнгө	6,475,855.5	7,050,402.3	574,546.8
Нийт хөрөнгө	7,504,693.3	8,557,459.7	1,052,766.4
Өр төлбөр	154.9	1,121.3	966.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,504,538.4	8,556,338.3	1,051,799.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,504,693.3	8,557,459.7	1,052,766.4

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо, өр төлбөр дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 781,905.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 463,409.4 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	318,496.2	781,905.6	463,409.4
Төгрөг	318,496.2	781,905.6	463,409.4
Төрийн сангийн харилцах	318,496.2	781,905.6	463,409.4
Арилжааны банк дахь харилцах	-	-	
Дүн	318,496.2	781,905.6	463,409.4

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансанд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 496,772.6 мянган төгрөг, сумын ОНХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл 242,310.6 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 42,822.4 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 189,573.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,770.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	10,682.7	27,746.3	17,063.6
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	-	-
Хувь хүмүүст олгосон зээл	189,661.1	161,826.9	(27,834.2)
Дүн	200,343.8	189,573.2	(10,770.6)

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 100 хувь буюу 189,573.2 мянган төгрөгийг ХХС-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ ХХС-ийн нийт 35-н зээлдэгчээс 5 зээлдэгч зээлээ бүрэн хаасан бол 1 зээлдэгчид шүүхийн маргаан үүсгэж, 19 зээлдэгчид зээлийн нэхэмжлэлийг хүргүүлэн ажилласан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 535,578.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,580.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал			
Бичиг хэргийн материал	2,410.6	1,773.6	(637.0)
Аж ахуйн материал	266,681.9	227,537.2	(39,144.7)
Сэлбэг хэрэгсэл	2,953.5	3,283.4	329.9
Түлш, шатах тослох материал			-
Барилгын засварын материал		668.8	668.8
Бусад хангамжийн материал	203,951.8	204,815.5	863.7
Мал амьтад	34,000.0	97,500.0	63,500.0
Дүн	509,997.8	535,578.6	25,580.8

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 25,580.8 мянган төгрөгөөр өссөн нь 358,117.0 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 71,479.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон 321,515.7 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулан, 82,500.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 7,050,402.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 574,546.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,342,410.2	6,844,983.0	502,572.8
Барилга, байгууламж, орон сууц	3,543,235.7	3,801,723.6	258,487.9
Авто-тээврийн хэрэгсэл	450,171.4	451,991.1	1,819.6
Машин тоног төхөөрөмж	111,807.0	115,125.4	3,318.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	35,929.2	44,201.7	8,272.4
Зам гүүрийн байгууламж	154,177.9	367,123.1	212,945.2
Бусад үндсэн хөрөнгө	2,047,088.7	2,064,818.1	17,729.3
Биет бус хөрөнгө	133,445.3	205,419.3	71,974.0
Программ хангамж	3,325.3	2,217.7	(1,107.6)
Бусад биет бус хөрөнгө	130,120.0	203,201.6	73,081.6
Дүн	6,475,855.5	7,050,402.3	574,546.8

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 574,546.8 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Аймгийн ОНӨГ-аас 26,000.0 мянган төгрөгийн Тоёота ланд круйзер автомашин, Улсын онцгой комиссоос 82,089.1 мянган төгрөгийн Мицубиши Эл 200 маркийн автомашин үнэ төлбөргүй шилжүүлэн авсан,
- Аймгийн цагдаагийн газраас 157,452.6 мянган төгрөгийн цагдаагийн кабоны барилга орлого авсан,
- Аймгийн ЗДТГ-с 3,000.0 мянган төгрөгийн 2 ширхэг, Сангийн яамнаас 17,950.00 төгрөгийн 5 ширхэг, нийт 7 ширхэг 20,950.0 төгрөгийн суурин компьютер орлогоор бүртгэж авсан,
- Дулаанхаан тосгоны захирагчийн албаны 10 ширхэг эзэмших газрыг 9,577.00 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын эзэмших газрыг 63,504.0 мянган төгрөгөөр үнэлж, орлогод авсан,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Эн би девелопмент ХХК”-ийн гүйцэтгэсэн 350м хатуу хучилттай 198,980.5 мянган төгрөгийн өртөгтэй асфальтан авто зам болон “Хөтөл цэнэг ХХК”-ийн гүйцэтгэсэн 57,391.3 мянган төгрөгийн 44 ширхэг гудамжны гэрэлтүүлгийг орлогоор бүртгэсэн,
- Аймгийн замын сангийн хөрөнгөөр Дулаанхаан тосгонд “Сайжрах шилтгээн ХХК”-ийн гүйцэтгэсэн 32 ширхэг гудамжны гэрэлтүүлгийг 59,584.9 мянган төгрөгийн орлогоор бүртгэсэн, Шаамар суманд “Эм Эм рөүд бридж ХХК” 59,991.0 мянган төгрөгийн 500м хайрган хучилттай зам орлогод авсан,
- Аймгийн БОГ-аас шилжүүлсэн 5,136.4 мянган төгрөгийн мотоциклийг орлогод авсан,
- Төсвийн хөрөнгөөр 39,415.74 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авснаас голлон шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 8,556,338.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,051,799.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	693,139.5	693,139.5	-
Хуримтлагдсан үр дүн	5,241,541.2	6,293,341.1	1,051,799.9
Өмнөх үеийн үр дүн	3,595,549.0	5,241,541.2	1,645,992.1
Тайлант үеийн үр дүн	1,645,992.1	1,051,799.9	594,192.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,569,857.8	1,569,857.7	-
Дүн	7,504,538.3	8,557,459.7	1,052,766.4

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Шаамар сумын ИТХ-ын “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 126 дугаар тогтоолоор 706,279.4 мянган төгрөгийн татварын орлого, 263,859.1 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт 970,138.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,370,624.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 41.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	706,279.4	1,036,798.9	330,519.5	146.8
Хувь хүний орлогын албан татвар	367,115.0	653,831.9	286,716.9	178.1
Үйл ажиллагааны орлого	140,000.0	186,327.1	46,327.1	133.1
Хөрөнгийн орлого	20,000.0	26,340.8	6,340.8	131.7
Хөрөнгө борлуулсны орлого	12,388.6	16,425.0	4,036.4	132.6
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	10,000.0	7,779.2	(2,220.8)	77.8
Малын тоо толгойн албан татвар	23,295.8	36,358.6	13,062.8	156.1
Бууны албан татвар	600.0	390.0	(210.0)	65.0
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	2,205.7	(794.3)	73.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	40,000.0	30,482.5	(9,517.5)	76.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,500.0	5,908.1	(2,591.9)	69.5
Газрын төлбөр	51,000.0	28,402.6	(22,597.4)	55.7
Газрын дуудлага худалдааны орлого	20,000.0	38,659.1	18,659.1	193.3
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	380.0	56.8	(323.2)	14.9
Байгалийн ургамал ашигласны төлбөр	10,000.0	2,891.3	(7,108.7)	28.9

Ойн нөөц ашигласны төлбөр	-	740.2	740.2	-
Татварын бус орлого	263,859.1	333,825.7	69,966.6	126.5
Хүү, торгуулийн орлого	220,000.0	305,966.5	85,966.5	139.1
Бусад орлого	43,859.1	27,859.2	(15,999.9)	63.5
Нийт дүн	970,138.5	1,370,624.6	400,486.1	141.3

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд:

- ХХОАТ-ын орлого 286,716.9 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлого 46,327.14 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн орлого 6,340.78 мянган төгрөгөөр,
- Хүү, торгуулийн орлого 85,966.5 мянган төгрөгөөр
- Хөрөнгө борлуулсны орлого 4,036.36 мянган төгрөгөөр,
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 740.2 мянган төгрөг,
- Малын тоо толгойн албан татвар 13,062.8 мянган төгрөгөөр, тус тус давж биелсэн байна.
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2591.9 мянган төгрөгөөр,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 2,220.8 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөр болон дуудлага худалдааны орлого 3,938.4 мянган төгрөгөөр,
- Бууны албан татвар 210.0 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамж 794,3 мянган төгрөгөөр,
- Бусад орлого 15,999.9 мянган төгрөгөөр
- Байгалын ургамал ашигласны төлбөр 7,108.7 мянган төгрөгөөр
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 9,517.5 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Үйл ажиллагааны орлого:** “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 1072 хувьцааны 2024 оны ногдол ашгийг иргэдэд тараасантай холбоотойгоор 33.1 хувиар давж биелсэн,
- **Цалин хөлс түүнтэй адилтгах орлого:** 286,716.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2024 оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- **Хөрөнгийн орлого:** 6,340.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь иргэдийн хадгаламж нэмэгдсэнтэй холбоотой хадгаламжийн хүүгийн орлогоос суутгах албан татвар нэмэгдсэнээс шалтгаалан тухайн орлого 31.7 хувиар давж биелсэн,
- **Хүү торгуулийн орлого:** 2024 онд сумдын 100 жилийн ой тохиосноор гаднаас ирэх аялагчдын урсгал нэмэгдсэнтэй холбоотой замын цагдаагийн торгуулийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор 39.1 хувиар давж биелсэн,
- **Малын тоо толгойн албан татвар:** Уг орлогыг үндэслэлгүй, багаар төлөвлөснөөс тус орлого 13,062.8 мянган төгрөгөөр буюу 56.1 хувиар давж биелсэн,
- **Газрын дуудлага худалдааны орлого:** 3 удаагийн дуудлага худалдаа амжилттай зохион байгуулагдсантай холбоотойгоор орлого 18,659 мянган төгрөгөөр давсан,

Тасарсан орлогууд:

- **Газрын төлбөр:** Анх орлогын төлөвлөгөөг 34,500.0 мянган төгрөгөөр тогтоосон боловч тодотголоор орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр 77,196.9 мянган төгрөг болгон нэмэгдүүлснээс шалтгаалсан,
- **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Татварын байцаагчгүй байсан учраас иргэн, аж ахуйн нэгжээс татвар, хураамжийг бүрэн төвлөрүүлээгүй,
- **Газрын төлбөр:** “Гацуурт ХХК”-тай холбоотой газрын маргаантай асуудлаар шүүхэд хандсанаас шалтгаалан 44.3 хувиар тасарсан,
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр:** Зэлтэр чиглэлийн зам тавих ажил дууссанаас шалтгаалан хайрганы борлуулалтгүй болсон буюу уг орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 23.8 хувиар тасарсан,
- **Байгалийн ургамал ашигласан төлбөр:** 2024 оны төсөвт аймгаас хэт өндрөөр төлөвлөгдөн ирсэнтэй холбоотой уг орлого 71.1 хувиар тасарсан,
- **Нэр заагдаагүй бусад орлого:** 2022, 2023 онд иргэдэд сумын ОНХС-р олгогдсон түрээсийн хүлэмжийн тухайн онд төвлөрөх орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой 36.5 хувиар тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 1,270,392.7 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 906,854.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 23,340.0 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 14,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 312,975.8 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 59,000.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 50,000.0 мянган төгрөг, ХХС-ийн оны эхний үлдэгдлээс 73,771.7 мянган төгрөг зэрэг нийт орлого, зарлагыг **2,696,335.0** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн 126 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 970,138.5 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 32,140.0 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 130,000.0 мянган төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлгийг 326,449.4 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 40,704.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 50,000.0 мянган төгрөг, ХХС-н оны эхний үлдэгдлээс 73,771.7 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 1,383,806.4 мянган төгрөг зэрэг нийт **3,007,010.2** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулахаар эцэслэн баталсан байна. Үүнд:

Санхүүжүүлэх эх үүсвэрийн өөрчлөлт:

- Үйл ажиллагааны орлогыг 115,225.3 мянган төгрөгөөр,
- Хүү торгуулийн орлого 107,791.0 мянган төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 113,413.7 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 13,473.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.
- Малын тоо толгойн албан татварын орлого 16,704.2 мянган төгрөгөөр,

- *Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 4,305,0 мянган төгрөгөөр,*
- *Газрын дуудлага худалдааны орлого 90,000.0 мянган төгрөгөөр,*
- *Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр 17,200.0 мянган төгрөгөөр,*
- *Нэр заагаагүй бусад орлого 29,140.9 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.*

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- *ЗДТГ-ын цалин болон тогтмол зардлыг 79,872.1 мянган төгрөгөөр,*
- *Дулаанхаан тосгоны захирагчийн албаны цалин болон тогтмол зардлыг 46,421.3 мянган төгрөгөөр,*
- *ОНХС-ийн зардлыг 13,473.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.*

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 1,036,798.8 мянган төгрөг, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 1,383,806.4 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 130,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 310,584.7 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 40,704.2 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 33,465.7 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 56,904.8 мянган төгрөг, ХХС-ийн оны эхний үлдэгдлээс 73,771.7 зэрэг нийт **3,066,036.3** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,692,376.8** мянган төгрөг буюу 89.5 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 20,893.5 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 4,804.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,405.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 944.8 мянган төгрөгөөр, томилолтын зардал 375.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 9,944.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 6.8 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 973.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 186,643.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 5 төсөл, арга хэмжээнд 427,310.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 185,000.0 мянган төгрөгийг зарцуулан 242,310.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, 1 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, 1 төсөл арга хэмжээ он дамжсан болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т *“нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн*

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 187.6 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 1,419.7 мянган төгрөг, ХХААГ-аас 400.0 мянган төгрөг, Биеийн тамир спортын газраас 800.0 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл хөгжлийн газраас хамтарсан багийн дэмжлэгт 3,214.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,871.1 мянган төгрөг, Түшиг- Цагааннуур чиглэлийн авто замын барьцаа хөрөнгө 21,552.7 мянган төгрөг зэрэг нийт **33,445.6** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс гэрэл цахилгааны зардалд 2,442.8 мянган төгрөг, шатахууны зардалд 626.4 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэл эд зүйлс 300.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,333.0 мянган төгрөг, урамшуулалд 4,447.7 мянган төгрөг, спортын арга хэмжээний зардалд 800.0 мянган төгрөг зэрэг нийт **9,949.9** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, үлдэгдэл 23,495.7 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Шаамар сумын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан 1 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 2 төсөл, арга хэмжээ, аймгаас эрх шилжүүлсэн 5 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг нийт 18 удаагийн цахим тендерийн урилгыг tender.gov.mn цахим хуудсанд нийтэлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шаамар сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн зардлын бүртгэл болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 3 зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,313,498.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,135.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн, автомашинуудыг цэнхэр дугаар тавьсан, зайлшгүй шаардлагатай зардлаас бусад зардлыг танасан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зардлуудыг хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчин Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зургийг хадгалан үлдээх зорилгоор **3,879.6** мянган төгрөгийг ЗДТГ-аас шилжүүлсэн боловч хүлээж аваагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	170	162	7	1
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	161	147	4	10
3	Сумын Засаг даргын Тамгын газар	161	160	1	
4	Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	161	161		
	Нийт дүн	653	630	12	11

Эх сурвалж: www.old.shilendans.gov.mn

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 653 мэдээллээс 630 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өмнөх аудитаар 8 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан **28,895.9** мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь “... нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд босго үнийн журмыг баримтлах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илүү цагийн хөлсийг илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоон, төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлогыг зөвшөөрөлгүйгээр зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн, хандив авч зарцуулсан, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, өр төлбөрөөр тайлагнагдаагүй зардлыг тайлант оны төсвөөс санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон бүртгэл тайлагналтай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнөөс Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	851.5	1	851.5	100
Албан шаардлага	6	39,991.0	6	39,991.0	100
Зөвлөмж	2	-	1		50
Нийт дүн	9	40,842.5	8	40,842.5	88.9

Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг уг аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн” болон

“ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын байцаагчийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 07/32-03 дугаар төлбөрийн актаар тогтоосон 29,747.1 мянган төгрөгийн төлбөрийн 86.6 хувийг буюу **25,764.1** мянган төгрөгийн зээлийн алдангийг эзэн холбогдогчоос бус ХХС-ийн төсвөөс төлж барагдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 1.5 дахь “*Сангийн хөрөнгө нь суманд хоршоо санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, сургалт зохион байгуулах, хяналт тавих, авлага барагдуулах, урамшуулал олгоход зориулагдана.*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **4,940,410.0** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 4,843,181.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 97,229.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн нийт **4,843,181.0** мянган төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зарлагыг тус бүр 2,421,590.5 мянган төгрөгөөр илүү,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг тус бүр 2,421,590.5 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Залруулаагүй алдаа:

- ЗДТГ нь барилгын **97,229.1** мянган төгрөгийн их засварын дүнгээр барилга байгууламжийн дүнг капиталжуулж, нэмэгдүүлэлгүйгээр “Их засвар” нэршлээр бүртгэж тайлагнасан,

Өгсөн зөвлөмж: Бүртгэл тайланд ангилал зөрүүтэй бүртгэсэн хөрөнгийг 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **27,194.9** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 23,566.9 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 3,628.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага:

ЗДТГ:

1. Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 330 дугаар шийдвэр болон 11 дүгээр сарын 07-ны өдрийн 2484 дүгээр шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай захирамжийг үндэслэн сумын ЭМТ-ийн дарга албан тушаалтай Б.Алтан-Өлзийгийн ажилгүй байсан хугацааны 7,584.0 мянган төгрөгөөс **4,000.0** мянган төгрөгийн цалин хөлсийг ЗДТГ-аас барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх “*Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ*”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх “*Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагад учруулсан хохирлыг буруутай албан хаагчаар нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Сумын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн эх үүсвэрээс “*Баяр наадмын зардал*”-д 106,975.8 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоосон боловч **1,524.2** мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “*Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Сумын ЗДТГ нь бүрдэл дутуу анхан шатны баримтаар нийт **10,279.7** мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- *ЗДТГ-ын байрны урсгал засварын төсөв, үнийн тооцоо судалгааг хийлгүйгээр нийт 9,189.7 мянган төгрөг,*
- *Төрийн албан хаагчдад “Эерэг өөрчлөлтийг хамтдаа” НҮТББ-аар сургалт хийлгэх гэрээ байгуулан 1,090.0 мянган төгрөг олгосон боловч сургалт хийгдсэн гүйцэтгэлийн баримтгүй.*

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр, баталгаажсан анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн, зориулалт бусаар нийт **7,763.0** мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

ИТХ:

- Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас хуралдааны зардалд 2,763.0 мянган төгрөг,

Дулаанхаан тосгоны Захирагчийн алба:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас наадмын үйл ажиллагаанд 5,000.0 мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан 3 дугаар хавсралтаар баталсан “*Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал*”, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж:

1. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Нийт албан хаагчдын цалингаас 6 дугаар сард “*Шаамарын хөгжил зуун жил*” НҮТББ-ын дансанд сумын 100 жилийн ойн хандив, Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөр акт зэргийг суутган шилжүүлсэн байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалингаас зөвхөн хуульд заасан суутгалыг хийж байх.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт: Сумын ЗДТГ нь тайлант онд нийт **3,628.0** мянган төгрөгийн бараа материалыг тухай бүр бичсэн шаардах хуудсаар бус сар бүрийн эцэст бөөн дүнгээр орлого авч, зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “*... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалын “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх

нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8.21 дэх “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ”, 8.21.(д) *Бараа материалыг ажил, үйлчилгээнд зарцуулах үед: “Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /нэр төрлөөр/, Кт. Бараа материал /нэр төрлөөр/”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр баримтжуулан бүртгэж байх зөвлөмж өгөв.

3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **6** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”*, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д *“Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм”* ХЗУЗ-д *“... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнийг үнэлж, данс бүртгэлээс хасах хэрэгтэй...”* гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зарлагыг	1	2,421,590.0			1	2,421,590.0	1	2,421,590.0				
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг	1	2,421,590.0			1	2,421,590.0	1	2,421,590.0				
ЗДТГ нь үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд барилгын 97,229.1 мянган төгрөгийн их засварыг капиталжуулалгүйгээр үлдэгдлээр бүртгэж тайлагнасан	1	97,229.1			1	97,229.1			1	97,229.1	1	97,229.1
Дүн	3	4,940,410.0			3	4,940,410.0	2	4,843,181.0	1	97,229.1	1	97,229.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ												
ИТХ	1	2,763.0			1	2,763.0						
ЗДТГ	3	19,431.9			3	15,803.9	2	3,628.0				
Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	1	5,000.0			1	5,000.0						
Сумын ТТЗ-ийн дүн	8	27,194.9			5	23,566.9	3	3,628.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Нийт 12 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1				1		
Дүн	1				1		
ТӨНӨХБАУХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой							
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөж, зохион байгуулаагүй	1	28,895.9			1	28,895.9	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой							
Түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулгасан	1	3,879.6			1	3,879.6	
Дүн	1	3,879.6			1	3,879.6	
Нийт дүн	3	32,775.5			3	32,775.5	